



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025. 04. 22 № 01/309
танай _____-ны № _____-т

Хандивын тайлангийн дүгнэлт

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Заамар сумын "Монгол ардын нам"-аас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Төв аймаг дахь Төрийн аудитын газар хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Заамар сумын "Монгол ардын нам" нь "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай" хуулийн 37 дугаар зүйлийн 37.8-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлангийн маягт, заавар"-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1-д заасны дагуу сумын нөхөн сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Нам, эвслээс дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төв аймаг дахь Төрийн аудитын газар хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Заамар сумын "Монгол ардын нам"-д иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Төрийн Аудитын стандарт MNS 6817:2020, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/49 дугаар тушаалаар батлагдсан зааврыг баримтлан "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай" хуулийн 55 дугаар зүйл, Улс төрийн намын тухай хуулийн 34 дүгээр зүйлтэй тус тус нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

Дүгнэлт

Заамар сумын "Монгол ардын нам" нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал хураасан өдрөөс хойш нөхөн сонгуулийн жилийн 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

412502312



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025. 04. 22 № 01/308
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ЗААМАР
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Заамар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцохоор "Монгол ардын нам"-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Заамар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцохоор "Монгол ардын нам"-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь

412502308

хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр (... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Заамар сумын Сонгуулийн хороонд

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ



**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМ АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД
ДЭВШҮҮЛЭН ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2025 он

АГУУЛГА

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1. Боловсрол
- 1.2. Эрүүл мэнд
- 1.3. Соёл
- 1.4. Спорт
- 1.5. Хөдөлмөр эрхлэлт
- 1.6. Орон сууцжуулах бодлого
- 1.7. Хүн ам, нийгмийн бүлэг бүрд чиглэсэн хөгжлийн бодлого

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

- 2.1. Эдийн засаг, төсөв санхүү

ГУРАВ. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 3.1. Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил
- 3.2. Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлт- Шинэ хоршоо хөдөлгөөн
- 3.3. Нийлүүлэгчийн зэрэгцээ үйлдвэрлэгч аймаг

ДӨРӨВ. НОГООН ЭДИЙН ЗАСАГ БА АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО

- 4.1 Төрөлжсөн аялал жуулчлал
- 4.2 Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл

ТАВ.БАЙГАЛЬ ОРЧИН - НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 5.1 Хүрээлэн буй орчин ба ногоон хөгжил
- 5.2 Үнэт баялаг ус
- 5.3 Байгаль орчинд ээлтэй уул уурхайн бодлого

ЗУРГАА. ХОТ ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРТ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 6.1 Хөгжлийг тэтгэсэн дэд бүтэц-Сумдын хөгжил
- 6.2 Зам дагасан хөгжил / Хөгжлийн зам, Хөгжил дагуулсан зам, Нутгийн зам/

ДОЛОО. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛ

- 7.1 Хүний эрх ба амар тайван аюулгүй орчин
- 7.2 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа
- 7.3 Цахим засаглал ба иргэдэд ойр төрийн үйлчилгээ

ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО:

1.1 БОЛОВСРОЛ

1.1.1. Хүний хөгжлийг хангаж иргэдэд үзүүлэх нийгмийн салбарын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулан, бүх шатны боловсрол, сургалтын байгууллагыг хүний хөгжлийн төв болгон хөгжүүлж, эрүүл ахуй, ээлтэй орчин, чанартай, хүртээмжтэй үйлчилгээг бий болгоно.

1.1.2. Сургуулийн өмнөх боловсролын, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд барьж, орчны стандартын дагуу хүүхэд бүрд ээлтэй, эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэн, цэцэрлэгийн ердийн болон хувилбарт сургалт, 5 настай хүүхдийн хамран сургалтыг нэмэгдүүлж, “Хүүхэд бүр цэцэрлэгт” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.3. Сургуулийн барилга, байгууламж, суудлын тоог эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үе шаттай нэмэгдүүлж, бүлэгдүүргэлтийг норматив хэмжээнд барьж, орчны стандартын дагуу хүүхэд бүрд ээлтэй, эрүүл аюулгүй орчинг бүрдүүлнэ.

1.1.4. Иргэд хөгжлийн төв байгуулна.

1.1.5. Багшийн мэргэжил, заах арга зүйн хөгжлийг хангах ажлыг зохион байгуулж, тэдний үйл ажиллагааг үр дүнгээр нь үнэлэх, багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, гадаад, дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулж, “Хөгжсөн багшаас чадварлаг суралцагч” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.1.6. Хүүхэд багачуудыг амьдрах арга ухаанд сургах хөдөлмөрт бэлтгэх хүүхдийн хөдөлмөрт зуслан байгуулна.

Сургуулийн спорт заалны өргөтгөл барина.

1.2.ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР:

1.2.1 Нийгмийн эрүүл мэндийн асуудлыг анхаарлын төвд байлгаж, иргэдэд эрүүл мэндээ хамгаалах, эрүүл аж төрөх дадал хэвшил олгох мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн, халдварт болон халдварт бус өвчнийг бууруулж, эрүүл дадал хэвшил, идэвхитэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэн, эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.

1.2.2 Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, чадавхыг бэхжүүлнэ.

1.2.3. Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэгсдийн тоог нэмэгдүүлж, эрүүл хооллот, дасгал хөдөлгөөний дадал хэвшлийг бий болгох аян, хөдөлгөөн өрнүүлнэ. Нийтийн биеийн тамирын талбай байгуулна.

1.2.4. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, эмийн хангалтын талаарх судалгаа гаргаж, санхүүжилт нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулна.

1.2.5. “Эрүүл хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлж, хүүхдийн шүдний урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэн, суманд шүдний тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.6. Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийг нэвтрүүлнэ.

1.2.7. Нярайн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, оношилгоо, эмчилгээг сайжруулан тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлнэ.

1.2.8. Эрүүл мэндийн хүний нөөцийн хангалт, ур чадварыг нэмэгдүүлнэ.

1.2.9. Сумдын бүсчилсэн эрүүл мэндийн төв байгуулна.

1.3.СОЁЛ УРЛАГИЙН САЛБАР

1.3.1 Төрт ёсны уламжлал, түүх соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл бий болгоно.

1.3.2 Соёл, урлагийн байгууллагын материаллаг бааз, мэргэжлийн боловсон хүчний хангалтыг сайжруулна.

1.3.3 Хүүхдэд зориулсан уран бүтээл, шинээр туурвисан болон шинэчлэсэн уран бүтээлийг хүн амын бүхий л давхаргад хүргэж, нийгмийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн санал, санаачилгыг дэмжсэн арга хэмжээ зохион байгуулж ажиллана.

1.3.4 Нийтийн номын санд цахим мэдээллийн сан бүрдүүлэн “Хүний хөгжил-мэдээллийн төв” болгон хөгжүүлнэ.

1.4 НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТ

1.4.1 Нийтийн биеийн тамирыг эрүүл аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон иргэдийг идэвхтэй хөдөлгөөнд уриалан, шилдэг тамирчдыг төрүүлэн гаргах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

1.4.2 Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчин бүрдүүлнэ.

1.4.3 Их спортыг хөгжүүлэн, бэлтгэл сургуулилтыг чанаржуулан, шилдэг тамирчдыг бэлтгэн гаргана.

1.5 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

1.5.1 Төр, хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр хөтөлбөр, төслийг хэрэгжүүлж, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэн, ажлын байр бий болгон хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлнэ.

1.5.2 Хувийн хэвшлийн дэмжлэг, тусгай сангуудын хөнгөлттэй зээл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар шинэ ажлын байр бий болгоно.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

2.1. Эдийн засаг, төсөв санхүү

2.1.1 Өсөлттэй, өгөөжтэй эдийн засагтай болох зорилт хэрэгжүүлж, бүх салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, хөгжлийн төслүүдийг хувийн хөрөнгө оруулагчидтай хэрэгжүүлэх бодлого хэрэгжүүлэн, татварын бааз суурийг тогтвортой нэмэгдүүлэх, татвар төлөгчдийг бодлогоор дэмжин, тогтвор суурьшилтай ажиллуулах, үйлчилгээг дэмжих замаар хөрөнгө оруулалтын өгөөжийг дээшлүүлж, өрсөлдөх чадвартай эдийн засгийг бий болгоно.

2.1.2 Хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлж, төр-хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулж, дэд бүтцийн болон нийгмийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

2.1.3 Хоршоо хөгжүүлэх хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулан жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлийн төслийг түлхүү дэмжиж ажиллана.

ГУРАВ. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

3.1 ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО:

3.1.1 ХАА-н үйлдвэрлэлийн хөгжлийн бодлогыг боловсронгуй болгож, удирдлага, зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлж, шинжлэх ухааны ололт, тэргүүн туршилагыг нэвтрүүлэн ажиллагсдын хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмжийг ахиулан үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан, ХАА-н бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ. Иргэдийнхээ бодит орлого, амьдралын чанарыг дээшлүүлнэ.

3.2 МАЛ АЖ АХУЙН САЛБАР

3.2.1 “Монгол мал 2”, “Монгол малчин” “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж, ашиг шим, хүртээмжийг сайжруулах, малын генийн санг хамгаалах, био технологийн ололтыг нэвтрүүлнэ.

3.2.2 Малыг эдийн засгийн эрэлтэнд байнга оруулах замаар малын тоо толгойг нэмэгдүүлэхгүй, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх бодлого баримталж ажиллана.

3.2.3 Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвар зүйн судалгааг үндэслэн төлөвлөх, мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоож, гоц халдварт өвчингүй тайван бүсийг баталгаажуулна.

3.2.4 Малын халдварт өвчингүй тайван байдлыг баталгаажуулан хадгалж, гадаад, дотоодын үйлдвэр цехийг чанартай түүхий эд бүтээгдэхүүнээр хангах боломжийг бүрдүүлнэ.

3.2.5 Малыг бүртгэлжүүлэх, ажлыг эрчимжүүлэх, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, малын гаралтай бүтээгдэхүүнийг мөнгөх, цахим тогтолцоог бүрдүүлнэ.

3.2.6 Монгол малын махны ач тусыг сурталчлан таниулж, мал бордох, үр ашигтай аргачлал технологийг нэвтрүүлж, зах зээлд нийлүүлэх мах сүүний хэмжээг нэмэгдүүлнэ.

3.2.7 Сүүний хэмжээг эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын сүүний үйлдвэрлэл, сүүгээ борлуулж буй малчдад сүүний урамшуулал олгох тогтолцоог холбогдох байгууллагуудтай хамтарч шийдвэрлэнэ.

3.2.8 Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир, ноос, ноолуур, түүхий эд тушаасан малчдад түүхий эдийн чанартай уялдуулан мөнгөн урамшуулах олгох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.

3.2.9 Малчид болон иргэдэд малын тэжээл тариалахад зориулж газар олгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах малын тэжээллэгийн бааз суурь нэмэгдүүлнэ.

3.2.10 Малчдын татварыг зориулалтын дагуу зарцуулна.

3.2.11 Мал нядалгааны цехтэй болно.

3.3 ГАЗАР ТАРИАЛАН:

3.3.1 “Атрын IV аян”-ыг эхлүүлэн аймгийн “Газар тариалангийн бодлого”, “Үр”, “Уринш бордоо, ургамал хамгаалал”, “Техник технологи, боловсон хүчний хангалт”, “Хүнсний ногоо, Жимс жимсгэнэ”, 5 дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

3.3.2 Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, мах сүүний чиглэлийн ферм, Гайхан аж ахуй, Тахианы аж ахуй байгуулах төслийг

хэрэгжүүлнэ. Хамгаалагдсан хөрс болон ил задгай талбайн тариалалт /төмс, хүнсний ногоо/-ыг нэмэгдүүлж, Хүлэмжийн цогцолбор аж ахуй, Цардуулын үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлнэ.

3.3.3 Тариалангийн талбайг хашаажуулах, ойн зурвас байгуулах замаар хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалах, үржил шимийг сайжруулах арга хэмжээг төр, хувийн хэвшлийн оролцоотой хэрэгжүүлнэ.

3.3.4 Техникийн шинэчлэлд онцгойлон анхаарна.

3.3.5 Газар тариалангийн үйлдвэрлэлд хөрс хамгаалах, тэг элдэншүүлгийг нэвтрүүлнэ.

3.3.6 Орон нутгийн онцлогт тохирсон элит сортын баталгаат үр үржүүлгийн ажлыг дэмжин, тариалалтад шаардлагатай үрийн нөөцийг сум дотооддоо бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.3.7 Таримлын оновчтой сэлгээг нэвтрүүлнэ.

3.3.8 Ил талбай, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлж, төрөлжсөн зоорийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногооны дотоодын хэрэгцээг жилийн турш тогтвортой хангана.

3.3.9 Жимс жимсгэний нэр төрлийг олшруулан тариалах талбайг нэмэгдүүлж, кластер аж ахуйг хөгжүүлнэ.

3.3.10 Хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулж, тариаланчдыг эрсдэлээс хамгаална.

3.3.11 Механикжсан зоорийн төслийг эрчимтэй байгуулна

ДӨРӨВ.БАЙГАЛЬ ОРЧИН - НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

4.1 Хүрээлэн буй орчин ба ногоон хөгжил

4.1.1 Байгаль орчны даац чадамжид суурилж хүний үйл ажиллагаанаас хамааралтай доройтлыг хязгаарлан зүйн зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах, үйл ажиллагааг, нутгийн иргэд тэдний үүсгэл санаачлагыг байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлж, ногоон хөгжлийг хангана.

4.1.2 Байгалийн үнэ цэнэ, өгөөжийг үнэлэн хамгаалж, байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг үрээдүй хойч үедээ өвлүүлнэ.

4.2 БАЙГАЛЬ ОРЧИН-НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО.

4.2.1 Агаар хөрсний бохирдлыг бууруулах, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлж, хүн амыг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2.2 Хог хаягдлыг цуглуулан тээвэрлэх, устгах, үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгон, хог хаягдлын дахин боловсруулах аж үйлдвэрлэлийн парк байгуулна.

4.2.3 Иргэд, байгууллагуудын идэвхи оролцоог нэмэгдүүлэн, төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.

4.3 ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ

4.3.1 Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэн, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг дэмжинэ.

ТАВ. ХОТ ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРТ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1 Хөгжлийг тэтгэсэн дэд бүтэц

5.1.1 Хот байгуулалт, зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулан иргэдийн ая тухтай амьдрах, тохилог орчныг бүрдүүлж шинжлэх ухааны үндэслэлтэй, хот байгуулалтын норм стандартын дагуу хөгжүүлэх зорилгоор хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй боллоо. Цаашид ногоон хөгжлийн чиг баримжаанд тулгуурлан эдийн засгийг бэхжүүлэн иргэдийн ая тухтай амьдрах тохилог орчныг бүрдүүлнэ.

5.1.2 Төсөвт байгууллагуудын барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, эх засвар хийх ажлуудыг улсын болон орон нутаг, хувийн хэвшил, гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ.

5.1.3 Газрын нөөцийн ашиглалт хамгаалалтыг сайжруулж, тариалангийн болон бэлчээрийн газруудын зүй зохистой ашиглалтыг нэмэгдүүлнэ.

5.1.4 Сумын үерийн хамгаалалтын даланг барих ажлыг үргэлжлүүлэн хийнэ. Сумын хүүхэд залуучуудын чөлөө цагаа зөв боловсон өнгөрүүлэх соёл амралтын хүрээлэнгийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

5.1.5 Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн их засварыг ажлыг гүйцэтгэж, хүүхдүүдийн сурч боловсрох таатай орчинг бүрдүүлж ажиллана.

5.1.6 Хямд орлогтэй орон сууц хотолборийг хэрэгжүүлж, иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

5.1.7 Орон нутгийн чанартай авто зам дээр угтах хаалга барьж байгуулна.

5.1.8 Сумын эмнэлгийг бүрэн засварлаж хүн амын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулна.

5.1.9 Цэвэрлэх байгууламж байгуулах ажлыг судлан холбогдох дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүдэх.

5.1.10 “Хүүхдэд ээлтэй дотуур байр” хотолборийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж

5.1.11 Ерөнхий боловсролын сургуулийн хуучин дотуур байр засварлах.

5.1.12 Багуудын автомашины зам болон гудамж талбайн замыг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт болон хувийн хэвشلүүдтэй хамтран хатуу хучилттай зам тавих.

5.1.13 Хог хаягдалыг ангилах, ачих, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж, стандартыг бий болгох, хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийг цэвэрлэж, нөхөн сэргээнэ.

ЗУРГАА. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛ

6.1 НУТГИЙН УДИРДЛАГА, БАГИЙН ХӨГЖИЛ

6.1.1 Төрийн бодлогын залгамж чанар, байгууллага хоорондын уялдааг сайжруулж, иргэдийн оролцоо, хяналт, ил тод байдлыг хангаж эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн өндөр ёс суртахуунтай, хариуцлагатай, хуулийг дээдэлсэн, авилгаас ангид төрийн албыг төлөвшүүлэх зарчмыг баримтална. 2018 онд ISO 9001:2015 олон улсын стандартыг нэвтрүүлж, баталгаажуулалтын гэрчилгээ авч, нийгмийн даатгалын үйлчилгээ нь аймаг орон нутагт анх удаа олон улсын стандарт нэвтрүүлж баталгаажуулаад байна.

6.1.2 Нутгийн өөрөө удирдах байгууллага болон бүх шатны төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж манлайллыг дээшлүүлэн, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг орон нутгийн түвшинд бүрдүүлнэ.

6.1.3 Сумын хэмжээнд төрийн албаны ажлын зохион байгуулалт, сахилга хариуцлага, ёс зүйг сайжруулах бодлого, хөтөлбөр батлан хэрэгжүүлж өндөр ёс суртахуунтай төрийн албыг бий болгож төлөвшүүлнэ.

6.2 МЭРГЭШСЭН, ЁС ЗҮЙТЭЙ ТӨРИЙН АЛБА

6.2.1 Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон үнэлж, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.

6.2.2 Цахим засаглалыг хэрэгжүүлж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн төрийн үйлчилгээ авах нөхцөлийг хялбаршуулан төрийн байгууллагын шуурхай, ил тод байдлыг хангана.

6.2.3 Сум багийн ажлын уялдаа холбоог сайжруулан багийн түвшинд шийдвэрлэх асуудлыг багийн ИНХ, багийн өдөрлөг, “Нээлттэй өдөрлөг” зэрэг олон нийтийн оролцоо санал бодол дээр тулгуурлан шийдвэрлэх ажлыг сайжруулна.

6.2.4 Нутгийн удирдлагын байгууллагын бодлого тодорхойлох, хэрэгжүүлэхэд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог сайжруулж төрийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг нэмэгдүүлэх бодлого баримтална.

6.2.5 Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернет цахим сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэх төрийн байгууллагын мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлж цаг алдалгүй шуурхай хүргэнэ.